

“УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 04-р сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

“Улсын их дэлгүүр” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04-р сарын 29-ний өдрийн 10:00 цагт цахим хэлбэрээр зохион байгуулав.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 22/06 тоот тогтоолоор томилогдсон хурлын дарга С.Сайнбат, тооллогын комиссын дарга, ахлах нягтлан бодогч Б.Даваасүрэн, тооллогын комиссын гишүүн хуульч Э.Төгсжаргал, хуульч Б.Сансар, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат, ахлах нягтлан бодогч Д.Чимгээ нарын бүрэлдэхүүнтэйгээр хурлын үйл ажиллагааг зохион байгуулав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын зард тусгасны дагуу компанийн байранд ирж болон цахим хэлбэрээр и-мэйл хаягаа бүртгүүлсэн хувьцаа эзэмшигчдэд цахимаар хийх хурлын заавар, цахим хуралд нэвтрэх линк, нууц үгийг бүртгүүлсэн и-мэйл хаягаар нь илгээн, хувьцаа эзэмшигчид илгээгдсэн цахим хурлын холбоосоор хурлын программд нэвтрэн орсноор хурлын ирцийг бүртгэх ажлыг тооллогын комисс 09:30 цагаас 10:00 цаг хүртэл хугацаанд хийлээ.

Хурлын үйл ажиллагааг 10:00 цагт эхлүүлэв.

Хурлын дарга С.Сайнбат: За “Улсын их дэлгүүр” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04 сарын 29-ний өдөр цахим хэлбэрээр зохион байгуулах тухай шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 сарын 18-ны өдрийн хурлаас гаргасан. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас хөдөө орон нутагт оршин суудаг хувьцаа эзэмшигч нарыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох боломжийг бүрдүүлэх зорилгоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Мөн энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах эрхийг ТУЗ-ийн ердийн гишүүн С.Сайнбат надад олгосон. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссыг Б.Даваасүрэн, Э.Төгсжаргал, Б.Сансар гэсэн 3 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байна. За ингээд “Хөвсгөл усан зам” ХК-ийн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхэлж байгааг мэдэгдье. Хурлын үйл явцыг бичлэг хийн баталгаажуулж байгааг та бүхэнд албан ёсоор мэдэгдье.

За ингээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудыг ТУЗ-өөс баталсныг та бүхэнд танилцуулъя.

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах.

2. ТУЗ-ийн 2022 оны зардлын төсвийг батлах.

Одоо та бүхэнд тооллогын комисс хурлын ирцийг танилцуулна.

Тооллогын комиссын гишүүн Э.Төгсжаргал: За энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 18,690,884 ширхэг хувьцааны саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид буюу нийт хувьцааны 50.77%-ийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцож байгаа учраас хурлын ирцийг хүчинтэйд тооцож байна.

Хурлын дарга С.Сайнбат: За хуралд нийт хувьцаа эзэмшигчдийн 50.77% нь онлайнаар оролцож байгаа учир хурлын ирц хүчин төгөлдөр болж байна. Хурлын ирц бүрдсэн учраас хурлын үйл ажиллагааг эхлүүлье. За нэгдүгээр асуудал буюу компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах асуудалд оръё. Компанийн үйл ажиллагааны тайланг ТУЗ-ийн дарга миний бие танилцуулъя. Хувьцаа эзэмшигчдэд энэхүү мэдээлэл материалыг урьдчилан хүргүүлсэн байгаа.

За ингээд хурлаар хэлэлцэх 1-р асуудал буюу компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах гэсэн асуудалд оръё.

Үйл ажиллагааны талаар:

Компанийн түрээсийн орлогыг нэмэгдүүлэх, дэлгүүрийн барилгын сэргээн босголт, шинэчлэлтийн ажлыг богино хугацаанд чанартай гүйцэтгүүлэх, өдөр тутмын ашиглалтын зардлыг хэмнэн ажиллахад анхааран ажиллаж байгаагаа Гүйцэтгэх удирдлага ТУЗ-ийн ээлжит хурлуудад байнга танилцуулсаар ирсэн.

“Улсын Их Дэлгүүр” ХК нь 2021 онд 5,011.6 сая төгрөгийн орлоготой, 4,864,5 сая төгрөгийн зардалтай, 147.1 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Дэлхий нийтийг хамарсан цар тахалын улмаас хөл хорио тогтоосонтой холбоотойгоор түрээслэгчдэд нийт 1,695.2 сая төгрөгийн түрээсийн хөнгөлөлт үзүүлж, улсын төсөвт 761.7 сая төгрөгийн татвар төлжээ.

Улсын их дэлгүүрийн барилгын сэргээн босголт, шинэчлэлтийн ажил болон ашиглалт үйлчилгээний талаар:

Улсын их дэлгүүрийн барилгад 2020 онд гарсан галын аюулын улмаас их хэмжээний хохирол учирсныг цар тахалын хүнд үед “Номин Холдинг” ХХК болон түүний хамаарал бүхий компаниуд, барилгын ажлын гүйцэтгэгчид, нийт хамтран ажиллагчдын бүх талын дэмжлэг туслалцаатайгаар хохирлыг арилгаж, барилгын сэргээн босголт, шинэчлэлтийн ажлыг амжилттай хийж дуусгалаа.

Бид барилгын дам нуруу, багана, хучилтын хүчитгэл хийж, давхруудын урсгал засвар, хүн тээврийн 2 ширхэг лифт, 1-6 давхрын урсдаг шатыг бүрэн засварлаж, ачааны лифтүүд болон цэвэр, бохир ус, цахилгаан, хөргөлт, салхивчийн инженерийн шугам сүлжээ болон дохиолол хамгаалалт, камержуулалтыг бүрэн шинэчлэн засварлалаа.

“Улсын Их Дэлгүүр” ХК нь 2021 онд 6 болон 7 зогсоолтой ачаа тээврийн 2 ширхэг лифт, 30 градусын налуутай урсдаг шат 2 ширхэг, 12 градусын налуутай урсдаг шал 2 ширхэг, барилгын дээврийн гэгээвч, галын болзошгүй эрсдэлээс сэргийлж галын дөлийг мэдэрдэг 0.6 м/па даралтаар 34 м радиусийн хүрээнд 12 метрийн өндрөөс шүршдэг, 360 градус эргэдэг, 50 метрт мониторинг хийдэг дэлхийн стандартад нийцсэн гал унтраагч автомат буу бүхий иж бүрэн систем, дэлгүүрийн зүүн, баруун талын эргэдэг шилэн хаалга, 3-7 давхарын агаар өгөх, сорох системийн шугам сүлжээг шинээр ашиглалтанд орууллаа.

Барилгын засвар, сэргээн босголтын ажлын гүйцэтгэлд хөндлөнгийн аудитын байгууллагаар аудит хийлгэн зардлыг баталгаажуулж, хүлээн авлаа.

Санхүүгийн тайлангийн талаар:

“Улсын их дэлгүүр” ХК-ийн 2021 оны тайлан тэнцэлд хөндлөнгийн аудит хийлгэх компаниар “Сүлд-Аудит” ХХК-ийг сонгосон бөгөөд тус компанийг нээлттэй сонгон шалгаруулалтын зарчмын дагуу ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхийн саналаар сонгосон байгаа.

“Улсын их дэлгүүр” ХК нь 2021 онд түрээслэгч нарт 1,695.2 сая төгрөгийн түрээсийн хөнгөлөлт үзүүлж, 5,011.6 сая төгрөгийн орлого олж, үйл ажиллагаанд 4,878,0 сая төгрөгийн зардал гарсан байна.

Үйл ажиллагааны зардлыг бүтцээр нь ангилж үзвэл 1.7 хувь буюу 83.6 сая төгрөгийг хөдөлмөрийн зардал, 40.3 хувь буюу 1,964.4 сая төгрөгийг ашиглалтын зардал, 1.9 хувь буюу 93.9 сая төгрөгийг барилгын урсгал засварын зардал, 14.0 хувь буюу 681.6 сая төгрөгийг үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, 33.2 хувь буюу 1,617.1 сая төгрөгийг зээлийн хүүгийн зардал, 2.9 хувь буюу 139.8 сая төгрөгийг үл хөдлөх хөрөнгийн болон газрын татвар, 6.0 хувь буюу 297.6 сая төгрөгийг бусад зардал эзэлж байна.

Өнгөрсөн оны жилийн эцсийн байдлаар нийт хөрөнгийн дүн 21,450.4 сая төгрөг, үүнээс эргэлтийн хөрөнгө 25.2 хувь буюу 5,406.1 сая төгрөг, эргэлтийн бус хөрөнгө 74.8 хувь буюу 16,044.3

сая төгрөгийг эзэлж байна. Эргэлтийн хөрөнгийн 89.1 хувь буюу 4,819.2 сая төгрөгийг мөнгө, авлага зэрэг түргэн хөрвөх хөрөнгө, 7.6 хувь буюу 406.8 сая төгрөгийг бараа материал, 3.3 хувь буюу 180.2 сая төгрөгийг урьдчилж гарсан зардал эзэлж байна. Эргэлтийн бус хөрөнгийн дийлэнх хувь болох 99.8 хувь буюу 22,936.5 (хуримтлагдсан элэгдэл нь 6,926.0 сая төгрөг) сая төгрөгийг үндсэн хөрөнгө болох барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, үлдэх 0.2 хувь буюу 33.8 сая төгрөгийг урт хугацаат хөрөнгө оруулалт эзэлж байна.

Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн хувьд бусдад төлөх өр төлбөрийн хэмжээ 24,347.8 сая төгрөг, эзэмшигчдийн өмчийн дүн -2,897.3 сая төгрөг байна. Нийт өр төлбөрийн 70.4 хувь буюу 17,142.4 сая төгрөгийг Хаан банкин дахь зээл, зээлийн хүү эзлэж байна. Эзэмшигчдийн өмч оны эхэнд -3.044,4 сая төгрөг байснаас оны эцэст -2.897,3 сая төгрөг болж нэмэгдсэн байна.

Компани нь татвараа үнэн зөв тодорхойлж, төлөх, тайлагнах үүргээ нэр төртэй биелүүлж, нийгмийн хариуцлагаа үлгэр жишээ ухамсарлаж, эх орныхоо бүтээн байгуулалт, хөгжил цэцэглэлтэд бодитой хувь нэмэр оруулан 2021 онд НӨАТатварт 597.3 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгийн албан татварт 126.3 сая төгрөг, ХХОАТатварт 7.7 сая төгрөг, НДШимтгэлд 16.9 сая төгрөг, газрын татварт 13.5 сая төгрөг, нийт дүнгээр 761.7 сая төгрөгийг Улсын төвлөрсөн төсөвт төлсөн байна.

2021 онд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурал хуралдсан бөгөөд хурлаас гарсан шийдвэрийг олон нийтэд болон хувьцаа эзэмшигчдэд хуулийн дагуу мэдээлэн ажилласан. Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн мэдээлэлд өөрчлөлт ороогүй байна.

Авлага, өглөгийн талаар:

Оны эхэнд дансны авлага 479.3 сая төгрөг байснаас оны эцэст 4,646.5 сая төгрөг болсон байна. Авлагыг ангилж үзвэл худалдан авагчдаас авах авлага 11.2 сая төгрөг, дотоодын бэлтгэн нийлүүлэгчдээс авах авлага 3,679.7 сая төгрөг, найдваргүй авлагын хасагдуулгын нөөцийн сан (23.4) сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татварын авлага 968.0 сая төгрөг, орлогын албан татварын авлага 10.8 сая төгрөг байна. Авлагын үлдэгдлийг хянахад үл хөдлөх хөрөнгийн даатгалын нөхөн төлбөрийн авлага 78.9 хувь буюу 3,667.5 сая төгрөг байна.

Оны эхэнд 10,954.5 сая төгрөгийн өглөгтэй байснаас оны эцэст 24,347.7 сая төгрөг болж 13,393.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Дансны өрийг ангилж үзвэл дотоодын бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх өр 28.0 хувь буюу 6,820.2 сая төгрөг, цалин, ногдол ашиг, хойшлогдсон татварын өр 2% буюу 385.3 сая төгрөг, зээл зээлийн хүүгийн өр 70.0 хувь буюу 17,142.2 сая төгрөг тус тус эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн талаар:

2021 оны эцэст цэвэр дүнгээр 16,010.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй ба тайлант жилд засвар, сэргээн босголтоор дэлгүүрийн барилга 6,111.6 сая төгрөгөөр, тоног төхөөрөмж 3,493.5 сая төгрөгөөр нэмэгдэж, 681.5 сая төгрөгийн элэгдэл байгуулж зардалд тооцсон байна. Даатгалын байгууллагаас 2021 онд ҮХХөрөнгийн даатгалын нөхөн төлбөрт 2,854.9 сая төгрөг шилжиж ирсэн байна. Дэлгүүрийн барилгын засвар, сэргээн босголтын зардлыг хөндлөнгийн аудитаар баталгаажуулсан байна.

ТУЗ-ийн төсвийн зарцуулалт:

Өмнөх оны бүх гишүүдийн хурлаар 2021 онд ТУЗ-ийн зардалд 14.0 сая төгрөг төлөвлөсөн ба тайлант хугацаанд ТУЗ-ийн гишүүдийн цалин, НДШ, ТУЗ-ийн болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлын зардалд 15.6 сая төгрөгийн зардал гарсан байна.

“Улсын Их Дэлгүүр” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг авч хэлэлцсэн бөгөөд хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүдийн 100 хувийн саналаар компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсэн болно.

Ногдол ашгийн хувьд компани тайлант жилийн болон өмнөх онуудын хуримтлагдсан алдагдлаа нөхөж чадаагүй, алдагдалтай ажилласан, мөн Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8 дахь хэсэг, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангаж чадахгүй байгаа учраас ТУЗ-ийн 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн хурлаар 2021 оны тайлант жилийн үйл ажиллагааны орлогоос хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

Хурлын дарга С.Сайнбат: За Ингээд хурлаар хэлэлцэх 2-р асуудал болох ТУЗ-ийн 2022 оны зардлын төсвийг батлах гэсэн асуудалруу оръё. Зардлын төсвийг доорх байдлаар төлөвлөж оруулсан байна.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2022 оны зардлын төсөв

(мянган төгрөгөөр)

1.Гишүүдийн цалин, НДШ /10 хүн*75,0 мян.төг*12 сар/	10,215.0
2.ТУЗ-ийн хурлын зардал	4,100.0
3.Тархалтын судалгаа, бичиг хэрэг, нотариатын зардал	1400.0
4.Унааны зардал	600.0
Үнийн дүн	16,315.0

Энэ зардалд ТУЗ-ийн болон хувьцаа эзэмшигчдийн хурлын бэлтгэл ажлыг хангахтай холбоотой зардлууд ордог, мөн ТУЗ-ийн хараат бус гишүүдэд олгодог цалин, НД-ын шимтгэлийн зардал гардаг.

Хурлын дарга С.Сайнбат: За хэлэлцэх асуудалдтай холбоотой танилцуулга ингээд дууслаа. Хувьцаа эзэмшигчдээс асууж тодруулах зүйл болон санал байна уу? гээд хэсэг хүлээв. (хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асуусан болон санал хэлсэн хувьцаа эзэмшигч байгаагүй)

Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуух асуулт болон санал байхгүй байна гэж ойлголоо. Ингээд хэлэлцсэн асуудлууд дээр санал хураая. Санал хураалтын үйл явц 20 минут үргэлжилнэ. Энэ хугацаанд хувьцаа эзэмшигчид саналаа өгч дуусгах ёстой байгаа. Санал хураалтын үйл явцыг тооллогын комисс болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга тайлбарлаж өгнө үү.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат: Хувьцаа эзэмшигч нарлуу бүртгүүлсэн и-мэйл хаягаар нь санал хураалтад оролцох линк явуулсан байгаа. Тухайн линкээр ороод хэлэлцсэн асуудлууд дээр цахим хэлбэрээр саналаа өгнө.

Хурлын дарга С.Сайнбат: За хурлаар хэлэлцсэн асуудлууд дээр хувьцаа эзэмшигчид саналаа өгч дууссан байна. Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулна уу.

Тооллогын комиссын гишүүн Э.Төгсжаргал: Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдээс Шагдарсүрэнгийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, Баярсайханы итгэмжлэгдсэн төлөөлөгч, Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль, Т.Гансүх, Ш.Цэцэгсүрэн нар санал хураалтад оролцсон байна. За санал хураалтын дүнг танилцуулъя. Нийт 18,690,884 ширхэг хувьцааны саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчид санал хураалтад оролцсон. Урьдчилан ирүүлсэн саналын хуудас байхгүй.

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах санал хураалтын дүн:
Зөвшөөрсөн - 18,651,633 ширхэг буюу 99.79%
Татгалзсан - байхгүй
Түдгэлзсэн - 39,250 ширхэг буюу 0.21%
2. ТУЗ-ийн 2022 оны зардлын төсвийг батлах тухай санал хураалтан дүн:
Зөвшөөрсөн - 180,651,633 ширхэг буюу 99.79%
Татгалзсан - байхгүй
Түдгэлзсэн - 39,250 ширхэг буюу 0.21%

Хурлын дарга С.Сайнбат: Тооллогын комиссын дүгнэлттэй танилцлаа. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 99.79 хувийн саналаар зөвшөөрч баталсан байна. Мөн ТУЗ-ийн 2022 оны зардлын төсвийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 99.79 хувийн саналаар зөвшөөрч баталсан байна.

Ингээд хурлын үйл ажиллагааг дуусгая. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нартаа баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 12:00 цагт дуусав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

М.ӨЛЗИЙБАТ

ТЭМДЭГЛЭЛИЙГ ХЯНАСАН:

ХУРЛЫН ДАРГА

С.САЙНБАТ